



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/238

Мөрөн сум

Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ханх сум, Хатгал тосгонд “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх Хөвсгөл дэд төсөл”-ийн хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутагт тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх үндэсний загварыг бий болгох, төсөл хэрэгжиж буй орон нутгийн байгаль хамгаалал, аялал жуулчлал, эдийн засгийн асуудлыг цогцоор шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хяналт тавих, санал зөвлөмж хүргүүлж ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнгөн-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Б.Оюунтуяа (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

П.Мөнхжаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Л.Даваабаяр (Ханх сумын Засаг дарга)

А.Баттүшиг (Хатгал тосгоны захирагч)

Д.Батчулуун (Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын дарга)

Б.Хандармаа (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн)

Ё.Батсайхан (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Аюушжав (Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Д.Мягмарсүрэн (Барилга техникийн хяналтын улсын байцаагч)

Н.Буян-Өлзий (Авто замын хяналтын улсын байцаагч)

Ч.Нямгэрэл (Эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч)

Г.Даваадорж (Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн ерөний инженер)

А.Энхжаргал (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Д.Сүхээ (Хөвсгөл Ус суваг ХХК-ийн ерөнхий инженер)

Нарийн бичгийн дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

6712010112

2.

2. Тухайн төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хяналт тавих, санал зөвлөмж хүргүүлж ажиллах чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган, явц, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/347 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН